Цагдаагийн газрын даргын 2019 оны 08
дугаар сарын 06-ны өдрийн Б/96
дүгээр тушаалын хавсралт

АЛБА ХААГЧДЫН 2019 ОНЫ 07 ДУГААР САРЫН
АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ЦАЛИН НЭМЭХ АЛБА ХААГЧДЫН НЭРС

| № | д/д | Овог, нэр | Албан тушаал, цол |
|---|---|---|---|
| **1 сар 20 хувь нэмж олгох алба хаагчдын нэрс** | | | |
| 1 | 1 | Батхүлэгийн Цээпилмаа | Зөрчлийн тоо бүртгэгч, цагдаагийн дэд ахлагч |
| 2 | 2 | Баатарын Пүрэвсүрэн | Аж ахуйн ажилтан, цагдаагийн дэслэгч |
| 3 | 3 | Мягмарсүрэнгийн Галбадрах | Цагдаа-зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч |
| 4 | 4 | Мягмарбуувэйн Баянзул | Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад |
| 5 | 5 | Даваагийн Бат-Оргил | Баянлиг сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч |
| 6 | 6 | Наранцэцэгийн Түмэннасан | Мөрдөгч, цагдаагийн ахмад |
| 7 | 7 | Баяртогтохын Жигмэд | Галуут сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч |
| 8 | 8 | Батсайханы Баасанцэрэн | Эргүүлийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч |
| 9 | 9 | Бат-Эрдэний Лувсандорж | Баян-Овоо сум дахь цагдаа, цагдаагийн дэд ахлагч |

_______000_______

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 08 сарын 06 өдөр Дугаар Б/97 Дуурсах

Ц.Баярдаваат олон нийтийн цагдаагийн
ажлаас чөлөөлөх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан “Олон нийтийн цагдаагийн дүрэм”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Баянхонгор сумын 2 дугаар багийн олон нийтийн цагдаа Цэдэвсүрэнгийн Баярдаваагийн хөдөлмөрийн гэрээг 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс дуусгавар болгож, ажлаас чөлөөлсүгэй.

2.Олон нийтийн цагдаагаас чөлөөлөгдсөн Ц.Баярдаваагийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны, нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг хураах, эдэлгээний хугацаа дуусаагүй үнийн зөрүүг нөхөн төлүүлж, тооцоо хийж дуусгахыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.

3.Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд болон чөлөөлөгдсөн иргэнд танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190345

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 08 сарын 06 өдөр Дугаар Б/98 Дуурсах

Г.Оюунчимэгийг олон нийтийн цагдаагаар томилох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 63.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар батлагдсан "Олон нийтийн цагдаагийн дүрэм"-ийн 2.3, 2.8, 3.1, 3.3, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Олон нийтийн цагдаагаар ажиллах хүсэлт гарган, сонгон шалгаруулалт, сургалтад хамрагдаж тэнцэж нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Ганболдын Оюунчимэгийг тухайн шатны Засаг даргын саналыг үндэслэн Баянхонгор сумын 2 дугаар багийн олон нийтийн цагдаагаар энэ оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн томилж, хөдөлмөрийн гэрээ байгуулсугай.

2. Олон нийтийн цагдаа Г.Оюунчимэгийн дадлагажуулагч багшаар хэсгийн байцаагч /цагдаагийн дэслэгч Д.Ариунцэцэг/-ийг томилсугай.

3.Олон нийтийн цагдаагаар шинээр томилогдсон Г.Оюунчимэгийг сурган дадлагажуулж ажиллахыг дадлагажуулагч багшид, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн /цагдаагийн ахмад М.Баянзул/, хүний нөөцийн асуудлыг хариуцан ажиллахыг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Шинээр томилогдсон олон нийтийн цагдаа нарт үнэмлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, холбооны, нэг бүрийн, хамгаалах хэрэгслийг тавьж олгохыг Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/-д үүрэг болгосугай.



20190347

5.Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал /-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2019 оны 08 сарын 06 өдөр Дугаар Б/94 Дуурсах

Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэн,
ажил хариуцуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/146 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Цагдаагийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 2.2.1, 3.1.3, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус Цагдаагийн газрын зарим тасгийн дарга нараас 2019 оны ээлжийн амралтаа эдлэх болсонтой холбогдуулж, албан үүргийг түр орлон гүйцэтгэх шаардлага бий болсон тул ээлжийн амралтаа эдэлж дуусах хүртэлх хугацаанд

-Мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Батаагийн ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад П.Дэлгэржаваар,

-Хэрэг бүртгэх тасгийн дарга, цагдаагийн хошууч О.Чулуунбатын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа Ж.Наранбаатараар,

-Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Мөнгөнтулгын албан үүргийг ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтын нэгдүгээр үндсэн зорилтын хүрээнд хийгдэх зарим чиг үүргийг хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч /цагдаагийн ахлах дэслэгч А.Алтантогоо/-оор, ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтын хоёр, гуравдугаар үндсэн зорилтын хүрээнд хийгдэх зарим чиг үүргийг урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн /цагдаагийн ахмад М.Баянзул/, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн /цагдаагийн хошууч Г.Анхбаяр/ нараар,



20190339

- Шуурхай удирдлагын тасгийн дарга, цагдаагийн хошууч С.Ариунбаярын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг жижүүрийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч В.Ганзоригоор,

-Захиргааны удирдлагын тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргалын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Г.Алтанхуягаар түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2.Цагдаагийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх алба хаагчид ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлэн мэдээ, тайланг заасан хугацаанд нь гаргаж хүргүүлж ажиллахыг хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, /цагдаагийн ахлах дэслэгч А.Алтантогоо/, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн ахмад М.Баянзул/, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, /цагдаагийн хошууч Г.Анхбаяр/, ахлах мөрдөгч, / цагдаагийн дэд хурандаа Ж.Наранбаатар/, /цагдаагийн ахмад П.Дэлгэржав/, жижүүрийн ахлах мөрдөгч /цагдаагийн хошууч В.Ганзориг/, хүний нөөцийн мэргэжилтэн, /цагдаагийн дэслэгч Г.Алтанхуяг/ нарт үүрэг болгосугай.

3.Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 06 өдөр Дугаар Б/95 Дуурсах

Ажлын үр дүнгээр цалин хасах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.8 дахь хэсэг, мөн хуулийн 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.4, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Алба хаагчийн ажлыг үнэлэх" /код 111/-ын 111.4.2, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын баримтад тооллого явуулсан дүнг хугацаанд нь явуулаагүй Бичиг хэргийн эрхлэгч, архивч, бичээч, цагдаагийн ахлагч Эрдэнэ-Очирын Мөнхгэрэлд албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 10 /арав/ хувиар хасаж олгосугай.

2. Хариуцсан алба хаагчиддаа мэргэжлийн удирдлагаар хангаж дахин зөрчил, дутагдал гаргахгүй ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д үүрэг болгосугай.

3. Цагдаагийн ахлагч Э.Мөнхгэрэлийн цалинг заасан хувь, хэмжээгээр хасаж олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190341

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2019 оны 08 сарын 06 өдөр    Дугаар 8/96    Дуурсах

2019 оны 07 дугаар сарын ажлын үр дүнгээр
цалин нэмэх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49,8 дахь хэсэг, Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.4, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Шагнал, урамшил олгох” /код 925/-ын 925.3.1, “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын “г”-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газрын даргын 2019 оны 10 дугаар зөвлөлийн хуралдааны шийдвэрээр 07 дугаар сард бусдыгаа хошуучлан, идэвх зүтгэл гарган, үр бүтээлтэй ажилласан 9 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээг 1 /нэг/ сар 20 /хорь/ хувиар нэмж олгосугай.

2. Ажлын үр дүнгээр цалин нэмэх алба хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх нэр бүхий алба хаагчдын цалинг заасан хувь, хэмжээгээр нэмж олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА    Ц.АНХБАЯР

(D)-Alban bichig-Tushaal-2019

20190343